8. Гүйцэтгэлийн баталгаа
9. Шалгалт болон туршилт
10. Баглаа боодол
11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
12. Даатгал
13. Дагалдах үзйлчилгээ
14. Чанарыг баталгаа
15. Төлбөр
16. Үнэ
17. Захиалгыг өөрчлөх
18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
19. Гэрээний үүргийг шилжүүлэх
20. Гүйцэтгэлийн хугацааг сунгах
21. Алданги оногдуулах
22. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
26. Маргааныг шийдвэрлэх
27. Гэрээнд ашиглах хэл
28. Гэрээнд мөрдөх хууль
29. Мэдэгдэл
30. Татвар болон бусад хураамж

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

2. Үйлчлэх хүрээ

2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.

3. Барааны гарал үүслийн улс

3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно

3.2 Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

4. Стандарт	4.1	Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байна. Тусгайлсан стандарт заагдаагүй тохиолдолд тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.
5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах	5.1	Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
	5.2	Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 5.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
	5.3	ГЕН-ийн 5.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
	5.4	Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
6. Бүртгэлийн гэрчилгээ	6.1	Гэрээгээр нийлүүлэгдэх эм нь Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн байна.
	6.2	Эмэнд бүртгэлийн гэрчилгээ аваагүй бол Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн мэдэгдэлийг эрх бүхий этгээдээс авснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх	7.1	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
8. Гүйцэтгэлийн баталгаа	8.1	Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан дун бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
	8.2	Нийлүүлэгч гэрээний ажлаа дуусгаж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 20.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
	8.3	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар захиалагч хүлээн зөвшөөрөх дараах төрлийн баталгаа байна. Үүнд:

		(а) Тендерийн баримт бичгийн Бүлэг VII-д заасан маягтаар гаргасан банкны баталгаа, эсхүл (б) Засгийн газрын бонд эсхүл (в) Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаас
	8.4	Нийлүүлэгч гэрээний ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
9. Шалгалт болон туршилт	9.1	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
10. Баглаа боодол	10.1	Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон гэрэл, чийг зэргийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих буулгах хангалттай төхөөрөмж байхгүй зэргийг харгалзсан байна.
	10.2	Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	11.1	Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
	11.2	Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
12. Даатгал	12.1	Үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр даатгуулна.
13. Дагалдах үйлчилгээ	13.1	Нийлүүлэгч ГТН-д заасан дагалдах үйлчилгээг гүйцэтгэнэ.

- 13.2 Хэрэв гэрээний үнэд тусгагдаагүй бол дагалдах үйлчилгээний зардлыг талууд харилцан тохиролцож нийлүүлэгчид төлнө. Энэ зардал нь захиалагчийн бусад гүйцэтгэгчид төлсөн ижил төстэй үйлчилгээний зардлаас хэтрэхгүй байна.
- 14. Чанарын баталгаа,**
- 14.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ үйлдвэрлэгдсэн, өмнө ашиглагдаагүй бөгөөд үйлдвэрлэсэн болон хүчинтэй байх хугацааг хангасан байна. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээ нь нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хадгалалтын хугацаатай барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй болохыг нийлүүлэгч баталгаажуулна.
- Мөн гэмтэл согоггүй бөгөөд гэрээний нөхцөлүүд болон техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагаас чанарын шаардлага хангаагүй үндэслэлээр хэрэглээнээс хасагдаагүй, орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.
- 14.2 Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр нийлүүлэгдсэнээс хойш 3 сарын дотор мэдэгдэнэ. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой барааг үнэ төлбөргүй солино.
- 15. Төлбөр**
- 15.1 Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурьдана.
- 15.2 Нийлүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай бараа нийлүүлэлтийн гүйцэтгэлийг захиалагчид хүргүүлнэ. Уг гүйцэтгэлд нийлүүлсэн бараа үйлчилгээний нэхэмжлэх, ГЕН-ийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагатай баримт бичгийг хавсаргана.
- 15.3 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 15.4 Гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 16. Үнэ**
- 16.1 Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвэл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 17. Захиалгыг өөрчлөх**
- 17.1 Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг өөрчлөх эрхтэй:

		(а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
		(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр
		(в) барааг хүргэх газар
		(г) нийлүүлэгчийн гүйцэтгэх үйлчилгээ
	17.2	Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид өөрчлөлт гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаа болон үнэд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг өөрчилнө. Өөрчлөлттэй холбоотой аливаа гомдол, саналыг захиалгыг өөрчлөх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид гаргана.
18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	18.1	ГЕН-ийн 17-т зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
19. Гэрээний үүргийг шилжүүлэх	19.1	Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
20. Гүйцэтгэлийн хугацаа сунгах	20.1	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
	20.2	Гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгч бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэхэд урьдчилан тооцоогүй нөхцөлийн улмаас хугацаа алдах байдал үүссэн бол захиалагчид шалтгаан, үргэлжлэх хугацааг бичгээр шуурхай мэдэгдэнэ. Мэдэгдлийг авсан даруй захиалагч байдлыг үнэлж гүйцэтгэгчийн ажлын хуваарийг сунгах шийдвэрийг алданги оногдуулах эсхүл оногдуулахгүй нөхцөлтэйгээр гаргаж гэрээнд өөрчлөлт оруулна.
	20.3	ГЕН-ийн 23-т өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгчийн нийлүүлэлттэй холбоотой үүргийн биелэлтийг хангуулах үүднээс ГЕН-ийн 21-д заасны дагуу алданги оногдуулна. ГЕН-ийн 20.2-т гүйцэтгэлийн хугацааг алданги оногдуулахгүйгээр сунгахаар тохирсон бол энэ заалт хамаарахгүй.
21. Алданги оногдуулах	21.1	ГЕН-ийн 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Дээд хэмжээнд хурсэн тохиолдолд захиалагч гэрээг ГЕН-ийн 22 дугаар зүйлийн дагуу цуцлах асуудлыг хөндөж болно.

22. Үүргээ биелүүлээгүйг ээс гэрээг цуцлах	<p>22.1 Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй:</p> <ul style="list-style-type: none"> (а) Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 20 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй; (б) Бараа нь гэрээнд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй; эсхүл (в) ГТН-д заасан хугацаанд тухайн барааны бүртгэлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг ирүүлээгүй бол. (г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална. (д) Нийлүүлэгч гэрээний бусад үүргээ биелүүлээгүй; <p>22.2 ГЕН-ийн 22.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогdon гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.</p>
23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал	<p>23.1 ГЕН-ийн 20, 21 ба 22-т заасныг үл харгалзан, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас хугацаа алдсан эсхүл гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх боломжгүй болсон гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа, алданги, эсхүл үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдах хариуцлагыг хүлээхгүй.</p> <p>23.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.</p>
24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	<p>24.1 Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.</p>

- | | |
|---|--|
| 25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах | <p>25.1 Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсныг болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.</p> <p>25.2 Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно. |
| 26. Маргааныг шийдвэрлэх | <p>26.1 Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцэл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.</p> <p>26.2 Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.</p> |
| 27. Гэрээнд ашиглах хэл | <p>27.1 Гэрээ нь ГТН-д заасан хэл дэр бичигдэнэ. ГЕН-ийн 28-д өөрөөр заагаагүй бол энэ хэл дээр бичигдсэн гэрээний хувилбарыг гэрээг тайлбарлахад мөрдөнө. Гэрээний дагуу талуудын харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.</p> |
| 28. Гэрээнд мөрдөх хууль | <p>28.1 ГТН-д заагаагүй бол Гэрээ нь Монгол улсын хуулийг мөрдөнө.</p> |
| 29. Мэдэгдэл | <p>29.1 Талууд гэрээтэй холбогдсон мэдэгдлийг бичгээр болон факсаар ГТН-д заагдсан хаягаар хүргүүлнэ.</p> <p>29.2 Мэдэгдэлийг түүний хүргэгдсэн өдөр эсхүл түүнд заасан хүчинтэй хугацааны аль сүүлчийн өдрөөс хүчинтэй гэж үзнэ.</p> |
| 30. Татвар болон хураамж | <p>30.1 Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас нийлүүлэх бараанд Монгол улсын гадна оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.</p> <p>30.2 Дотоодоос нийлүүлэх бараанд захиалагчид нийлүүлэгдэх хүртлэх хугацаанд түүнд оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.</p> |

ДОЛДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)	
ГЕН 1.1 (и)	Захиалагч нь Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нь төндөрт шалгарч гэрээ байгуулсан оролцогчид
ГЕН 1.1 (н)	Байршил: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын эмийн сангийн агуулах
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагууд
8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)	
ГЕН 8.1	Гэрээний үнийн дүнгийн 5%-иар тооцож гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
ГЕН 8.4	Гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгох бусад нөхцөлүүд байхгүй.
9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)	
ГЕН 9.1	Нийлүүлэгдэж буй эм, эмнэлгийн хэрэгсэл нь техникийн тодорхойлолтод зааснаас зөрөх, чанарын хувьд шаардлага хангахгүй, ноцтой гаж нөлөө инэрсэн тохиолдолд тусгай комисс шалгалт туршилт явуулна.
10. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)	
ГЕН 10.2	Техникийн тодорхойлолтод тусгагдсан
11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН-ийн Зүйл 11)	
ГЕН 11.1	<p>Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:</p> <p>Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, ачсан боомт, боомтоос гарах огноо, тээврийн хэрэгслийн нэр, буулгах боомт зэргийг дурдана.</p> <p>Нийлүүлэгч дараах баримт бичгийг захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ: Барааг онгоцоор тээвэрлэх тохиолдолд нислэгээс дор хаяж 48 цагийн өмнө тээврийн хэрэгслийн нэр, нислэгийн дугаар, бараа ирэх хугацаа, тээврийн баримтын дугаар зэргийг захиалагчид мэдэгдэнэ.</p> <p>Захиалагч мэдэгдлээ факсаар ирүүлж дараах баримт бичгийг захиалагчид, хуулбарыг даатгалын компанид баталгаат шуудангаар хүргүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2. Нийлүүлэгчийн нэхэмжлэхийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувь. Үүнд захиалагчийн нэр, хаяг [гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих]; гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг зааж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна; 3. Захиалагч [гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих] болон гэрээнд заасан бусад мэдэгдэх байгууллагыг дурдаж, Техникийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувийг болон бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 2 ширхэг хуулбар хувийн хамт; эсхүл Техникийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий 3 хувь баримт

- барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;
- Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар;
- Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг хуулбар хувь
- Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн Шалгалтын гэрчилгээний үндсэн хувь;
- Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг
- “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар

Монгол улсын дотроос нийлүүлэх барааны хувьд:

Гүйцэтгэгч бараа хүрэлцэн ирэхэд эсхүл ирэхээс өмнө захиалагчид бичгээр мэдэгдэж дор жагсаасан баримт бичгийг захиалагчид өгсөн байна. Үүнд:

- Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан нийлүүлэгчийн нэхэмжлэхийн хувь; 2 ширхэг үндсэн, 2 ширхэг хуулбар хувь
- Нийлүүлэлтийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор тэмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн бараа хүргэсэн баримт, 2 хувь
- Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар
- Барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;
- Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг үндсэн хувь
- Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн шалгалтын гэрчилгээний хуулбар хувь;
- Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг
- “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар

Санамж: Нийлүүлэгчийн ирүүлсэн баримт бичиг нь гэрээний шаардлагад нийцэхгүй бол төлбөрийг ГТН-ийн 9 (ГЕН 9)-ийн дагуу хийх шалгалт туршилтын дүнг үндэслэн төлнө.

14. Чанарын баталгаа (ГЕН-ийн Зүйл 14)

ГЕН 14.2 Гэмтэлтэй барааг солих хугацаа: **Ажлын 5 хоног.**

15. Төлбөр (ГЕН-ийн Зүйл 15)

ГЕН 15.1 & 15.4 Энэ гэрээний дагуу гүйцэтгэгчид хийх төлбөрийг дараах нөхцөлөөр хийнэ.

Монгол улсын гаднаас санал болгосон барааны төлбөр:

Төгрөгөөр хийх төлбөр дараах байдлаар төлгөгднө:

- Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөр олгогдохгүй.
- Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Бараа ачигдсаны дараа төлбөр олгогдохгүй.
- Барааг хүлээн авахад төлөх:** Бараа нийлүүлэх хуваарийн дагуу ирсэн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг,

тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.

Монгол улсын дотроос санал болгосон барааны төлбөр:

Монгол улсын дотроос нийлүүлсэн барааны төлбөр нь төгрөгөөр дараах байдлаар хийгдэнэ. Үүнд:

1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөр олгогдохгүй.
2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Бараа ачигдсаны дараа төлбөр олгогдохгүй.

Барааг хүлээн авахад төлөх: Бараа нийлүүлэх хуваарийн дагуу ирсэн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.

16. Үнэ (ГЕН-ийн Зүйл 16)

ГЕН 16.1	Гэрээний хэрэгжилтийн явцад үнэ тогтмол байна.
----------	--

20. Хугацаа сунгах (ГЕН-ийн Зүйл 20)

ГЕН 20	Захиалагч гүйцэтгэгчтэй тохиролцон гэрээний хэрэгжилт дуусаад дараагийн тендериийн гэрээ байгуултал гэрээг сунган ажиллаж болно.
--------	--

21. Алданги оногдуулах (ГЕН-ийн Зүйл 21)

ГЕН 21.1	Алдангийн хувь нь долоо хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь, суутгах дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь байна.
----------	--

22. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 22)

ГЕН 22	Нийлүүлж буй эм, эмнэлгийн хэрэгсэл нь хугацаандaa нийлүүлэгдээгүй, захиалагчийн техникийн тодорхойлолтод зааснаас зөрөх, чанарын шаардлага хангахгүй, хэрэглэгчдэд сэргээр нөлөөлсөн нөхцөлд гэрээг цуцална.
--------	---

25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)

ГЕН 25	Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй болон хугацаа алдсан, чанаргүй бараа нийлүүлсэн, барааг сольж олгосон зэрэг бусад шалтгаанаар эмчилгээ үйлчилгээнд сэргээр нөлөөлөхөөр бол гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалж болно.
--------	---

26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)

ГЕН 26	Маргааныг талууд зөвшилцлийн дагуу шийдэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
--------	---

27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)

ГЕН 27.1	Гэрээнд Монгол хэлийг ашиглана.
----------	---------------------------------

28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)

ГЕН 28.1	Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө
----------	--

29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)

ГЕН 29.1	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9, Хангарди ордон, 9 дүгээр давхар [Нийлүүлэгчийн хаягыг бичих]
----------	--

НАЙМДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож
_____ оны _____ сарын _____-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэрийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-нээс _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу [Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт] (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс [баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг] –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан [баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг]-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот **[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж **[Захиалагчийн нэр]-ийн** өмнө хариуцлага хүлээж **[Баталгааны мөнгөн дүн]** **[үсгээр]**-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, валют]** **[дүн үсгээр, валют]**-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэл хүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг: